



НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА  
Ц.УРТНАСАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.4.23 № 02/92

Зөрчил арилгуулах тухай

Нийгмийн даатгалын сангийн 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

2006 оноос өмнө үүссэн 113 аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн нэр дээрх 9.643.1 сая төгрөгийн авлагыг барагдуулах талаар ажил зохиож байгаа хэдий ч шийдвэрлээгүй өдий хүрсэн байна. Хамгийн өндөр дүн бүхий авлагатай байгууллагыг дурдвал: Өгөөж богд ХХК-иас 2,273.2 сая, Сэргээн босголт банкнаас 2,066,6 сая, ХОТШ банкнаас 1,595.7 сая, Монгол бизнес банкнаас 200.0 сая, Экзим банкнаас 753.2 сая төгрөгийн авлагууд барагдуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг зөрчсөн байна.

Нийгмийн даатгалын сангийн НББ-ийн бодлогын баримт бичигт НДЕГ-ын системийн нэгдсэн санхүүгийн тайланд НДШ-ийн авлагын үлдэгдлийг бодитой тайлагнах, банк санхүүгийн олон улсын байгууллагуудаас тавьж байгаа шаардлагыг хангах зорилгоор НДЕГ-ын түвшинд найдваргүй авлагын нөөцийн сан байгуулаагүй,

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1-д "...алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэсэн заалтыг үндэслэн албан шаардлагыг өгч байна.

Дээрх 9.643.1 сая төгрөгийн найдваргүй, эзэн холбогдогчгүй, дампуурсан байгууллага, иргэдээс авлагыг барагдуулах, холбогдох шатны хуулийн байгууллагад хандан шийдвэрлүүлж 2013 оны IV улиралд багтаан биелэлтийг Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Нийгмийн даатгалын сангийн дарга болон хариуцсан албан тушаалтан, мэргэжилтэн нарт даалгав.

АУДИТОР



Б. ДАВААБААТАР

070185